ЭМ СУДЛАЛЫН ТЭНХИМ 70 ЖИЛД

Г.Энхмаа[1], Г.Чойжамц[2], Ч.Ерөөлт[1]

[1] Эм судлалын тэнхим, БАС, АШУҮИС
[2] Оточ манрамба их сургууль

Түүх гэдэг бол орон зай, цаг хугацааны шалгуур, үнэн зөвийн гэрэл гэгээ, сургамж, амь орсон дурсамж, дурдатгал, амьдралын багш, хөгжлийн түүчээ, үзэл баримтлал, өнгөрсөн үеийн дуу хоолой, үргэлж мөнхөд судлах, бахархан дээдлэх, мөнхийн тавилантай үнэт эрдэнэ учраас түүхээ бичиж үлдээх нь бидний үүрэг билээ.

Хүн төрөлхтөн эрт дээр үеэс ургамал, эрдсийн эмт чанарыг танин мэдэж, өвчин эмгэгийг анагаах зорилгоор хэрэглэж ирсэн түүхийг нотлох эд, судар ном, сурвалж бичиг, шастирт бичигдэн үлдсэн нь өнөө үе хүртэл өвлөн хадгалагдаж ирсэн ба орчин үеийн эм судлалын туршилт судалгаа шинжилгээний үндсэн дээр шинжлэх ухааны үндэслэлтэй баримт болсон байна.

Монголын уламжлалт анагаахын алдарт эмч, оточ нарын бичиж эдүгээ бидэнд өвлөн үлдсэн, албан ёсоор бүртгэгдсэн Ишбалжирын зохиосон “Дөрвөн рашаан”, “Эмийн нэрс ба эмт бодисыг таних болор толь”, Жамбалдоржийн ”Үзэсгэлэнт нүдэн чимэг”, Заябандида Лувсанпэрэнлэйн “Саруул сан” “Анагаах ухааны дөрвөн үндэс”, Галсанжамбын “Эмийн сударт өгүүлсэн он-жад нэрсийн тайлбар оршвой”, Лүндэг Дандарын “Жүдшийн тажод”, “Дөрвөн үндсийн гарсан толь хиргүй биндэръя”, “Эмийн дөрвөн үндсийн зарим дохионы утгыг тайлбарласан Намжил Арурын эрхсийн үзэсгэлэнт чимэг”, “Дөрвөн үндсийн нөхвөр-Лхантавын бэрх үгсийн тайлбар Намжил сэрдогийн эрих”, Ишданзанванжилын “Шүрэн чимэг”, “Эрдэнэчимэг”, “Сувд чимэг”, “Эмнэлгийн шүлэг зуун тавин дөрвөн бадаг” зэрэг дөрвөн дэвтэр, Агваангэндэнгийн “Чулуун эмийн тухай тэмдэглэл”, Ёндонмаарамбын “Цогт дөрвөн үндэсний тайлбар нэр нүүрийг тодотгогч толь”, Жигмэдданзанжамцийн “Үзэгсдийн баясгалан”, Чойжамцын зохиосон “Маш гайхамшигт хуримын сан”, Жалсан-Одсэрийн зохиосон “Бүхнээ туслах рашаан эмийн найрлага” зэрэг олон арван зохиол бүтээлд өвчнийг оношлох, эмчлэх, эм найруулах, эмт бодисыг таних арга зүйн талаар бичсэн байгаа нь Монголчууд эм судлалын ухааны эртний баялаг мэдлэгтэй бөгөөд чухамдаа хойч үеийнхэн бидэнд шинэ эмийн бэлдмэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг гарган авах эх сурвалж үндэс нь энд л байгааг харуулж буйг анхааралтай гэсэн санаа юм.

Монголд шинжлэх ухааны үндэслэлтэй орчин үеийн эм судлал хөгжих эх суурь БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1940 оны 12-р сарын 06-ны өдрийн 45-р тогтоолоор Монгол улсын университет байгуулах шийдвэр гарснаар эхэлсэн билээ. 1944-1945 оны хичээлийн жилээс эхлэн хүн эмнэлгийн факультетын оюутнуудад ЗХУ-ын мэргэжилтэн Ф.А.Самайлович, В.А.Воровская, дэд эрдэмтэн А.П.Халенов нар эм судлалын хичээлийг зааж эхэлсэн байна. 1949-1950 оны хичээлийн жилээс Эм судлалын тэнхим бие дааж байгуулагдан, ЗХУ-аас уригдан ирсэн мэргэжилтэн дэд эрдэмтэн, доцент А.А.Никулин анхны эрхлэгчээр, үндэсний анхны эм судлаач Цэрэндоржийн Ламжав дагалдан багшаар ажиллаж, хүн эмнэлэг ба мал эмнэлгийн хоёр салбарт эм судлалын хичээл зааж байжээ. 1953-1954 оны хичээлийн жилд ЗХУ-ын мэргэжилтэн дэд эрдэмтэн Н.В.Сапежинская, 1956-1957 оны хичээлийн жилд дэд эрдэмтэн Г.А.Деттерер тэнхимийн эрхлэгчээр, багшаар Ц.Ламжав, Ж.Цогнэмэх нар ажиллаж байв.

Багш Д.Балдандорж 1958 онд ЗХУ-ын Одессийн Анагаах ухааны сургуульд аспирантурт суралцан, дэд эрдэмтний зэрэг хамгаалж ирээд, тэнхимийн эрхлэгчээр ажиллаж эхэлснээр үндэсний мэргэжилтэн анх тэнхим удирдаж эхэлсэн түүхтэй. 1960-1961 оны хичээлийн жилд МУИС-ийн хүн эмнэлгийн факультет биеэ даасан Анагаах ухааны дээд сургууль болж, анхны захирлаар нь дэд эрдэмтэн Д.Балдандорж томилогдон, Эм судлалын тэнхимийн эрхлэгчээр ахлах багш Ж.Цогнэмэх томилогдож, 1990 он хүртэл 30 жил тус тэнхимийн сургалт, эрдэм шинжилгээний ажлыг удирдан хөгжүүлсэн түүхтэй.

Эм судлалын тэнхимийн эрхлэгчээр 1990-1996 оны хичээлийн жилд АУ-ны доктор, профессор М.Чүлтэмсүрэн, 1996-2002 онд АШУ-ны доктор, профессор Л.Мягмар, 2003-2013 онд АУ-ны доктор, профессор Г.Чойжамц, 2013-2015 онд АУ-ны доктор, дэд профессор П.Батхуяг нар тус тус ажилласан ба 2015 оноос одоог хүртэл АУ-ны доктор, дэд профессор Ч.Ерөөлт ажиллаж байна.

Эм судлалын тэнхим нь зохион байгуулалтын хувьд бэхжиж сургалт хүмүүжлийн чанарыг дээшлүүлэх, эрдэм шинжилгээ судалгааны багаж тоног төхөөрөмжөөр хангах, хичээлийн хөтөлбөр үзүүлэн материалыг шинэчлэн бэлтгэх, судалгаа шинжилгээний ажлыг орчин үеийн түвшинд явуулах талаар нөр их хөдөлмөр гарган ажилласны үр дүнд сургуулийн тэргүүний тэнхимийн хэмжээнд үнэлэгдэх болсон юм. Эм судлалын тэнхим өнгөрсөн хугацаанд сургалт хүмүүжил, эрдэм шинжилгээнийхээ үзүүлэлтээр сургуулийн хэмжээнд 1-р байрт 6 удаа, 2-3-р байрт 5

удаа, 2010 онд Анагаах Ухааны сургуулийн, 2017 онд Био анагаахын сургуулийн “Шилдэг тэнхим”-ээр тус тус шалгарсан. Эм судлалын тэнхимийн багш нар эмч, эм зүйч, АУ-ны их дээд сургуулийн оюутан, эмнэлгийн бусад мэргэжилтнүүдэд зориулж сурах бичиг, ном товхимол, гарын авлага 90 орчмыг бичиж нийтийн хүртээл болгожээ.

Профессор М. Чүлтэмсүрэн, багш, АУ-ны док, дэд проф. Ч. Ерөөлт нарын бичсэн “Эм судлал” сурах бичиг, “Эмийн лавлах”, “Жор судлал”, “Эмийн 1000 жор”, дэд профессор П. Батхуягийн бичсэн “Клиникийн эм судлалын үндэс”, “Зайлшгүй шаардлагатай эмийн лавлах” зэрэг ном хэвлэгдэн гарсан нь сургалт болон эмийн зохистой хэрэглэгээнд үнэлж баршгүй ач холбогдолтой зүйл болсон юм. Суралцагчдын сурах идэвхийг өрнүүлэх, оюутны бие даасан үйл ажиллагааг сайжруулан идэвхжүүлэхийн тулд 2009 оноос хойш Проф. М.Чүлтэмсүрэнгийн нэрэмжит эм судлалын улсын олимпиадыг тогтмол зохион байгуулж байна.

Тус тэнхим 2010 онд анх удаа “Клиникийн Эм судлалын үндэсний анхдугаар семинар”-г зохион байгуулж, эмийн эмчилгээний олон улсын удирдамж, эм хангамжийн үйл ажиллагааны талаарх онол, практикийн үйл явцыг нэгтгэн авч үзсэн бөгөөд үүнээс хойш клиник эм судлал, эмийн эмчилгээ, эмийн зохистой хэрэглээний сургалтыг тасралтгүй явуулж байна.

Эм судлалын тэнхим нь Анагаах, МУА, НАС, Эм зүй, Биоанагаахын сургуулийн оюутнууд, эмч, эм зүйч, магистрант болон докторант нарт төгсөлтийн өмнөх, төгсөлтийн, төгсөлтийн дараах сургалтаар жор судлал, эм судлал, клиник эм судлал, туршилт судалгааны эм судлал зэрэг хичээлийг зааж байна. Эм судлалын эрдэм шинжилгээ судалгааны ажил анх МУИС-ийн эм судлалын тэнхимд хийгдэж эхэлсэн ба 1951-1952 оны хичээлийн жилээс Эм судлалын тэнхимийн дэргэд оюутны эрдэм шинжилгээний бүлгэм зохион байгуулагдан, онол практикийн бага хуралд илтгэл хэлэлцүүлж байжээ. МУИС-ийн оюутны эрдэм шинжилгээний хурал 1943 онд анх зохион байгуулагдахад оюутан Маяа буюу Монгол улсын Хүний гавъяат эмч, Анагаах ухааны доктор, профессор Ч.Долгор “Эмийн ургамлын тухай” илтгэл тавьж байсан тухай мэдээ архивын баримт бичигт хадгалагдан үлдсэн байна. Эм судлалын судалгааны ажил 1956 оноос эрчимтэй хийгдэж эхэлсэн бөгөөд 1958 онд Д.Балдандорж, 1959 онд Ц.Ламжав нар ЗХУ-д аспирантурт суралцан төгсөж, эм судлалын мэргэжил эзэмшин, дэд докторын зэрэг хамгаалж ирснээс хойш ахицтай хөгжих боломж нээгдсэн байна.

Эм судлалын тэнхимийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын гол зорилго нь Монгол орныхоо байгалийн баялаг болон уламжлалт анагаах ухааны арвин баялаг сан хөмрөгт тулгуурлан эмийн ургамлын биологи, фармакологийн үйлдлийг тэдгээрт агуулагддаг гол ба дагалдах нэгдлүүдтэй холбон судалж шинжилсний үндсэн дээр ургамлын гаралтай шинэ эмийн бэлдмэл, биологийн идэвхит бүтээгдэхүүн гарган авах, эмнэлзүйн эм судлалын судалгаа, эмийн зохистой хэрэглээний судалгаа хийх зэрэг болно. Энэ зорилгын хүрээнд эх орны эмийн ургамлын тархалтыг судлах, тэмдэглэх, дээж цуглуулах зэргээр олон удаагийн экспедиц зохион байгуулж, 1955-1959 онд доктор Ц.Ламжав, 1959-1973 онд доктор, доцент Ж.Цогнэмэх, 1973-1996 онд доктор, профессор М.Чүлтэмсүрэн, 1996-2002 онд доктор, профессор Г.Чойжамц, 2013-2015 онд доктор, дэд проф П.Батхуяг, 2015 оноос одоог хүртэл доктор, дэд проф. Ч.Ерөөлт нар тус тус удирдаж ажиллажээ.

Тус тэнхимийн багш профессор Д.Балдандорж Алтан гагнуур, дэд проф. Ж.Цогнэмэх Үсхий нохойн хэл, профессор М.Чүлтэмсүрэн Хотой, профессор Л.Мягмар Каринтины дэгдгэнэ, Азийн төлөгч өвс, профессор Г.Чойжамц Харлаг үмхий өвс, профессор П.Цэдэн Толгодын бударгана, дэд проф. П.Батхуяг Нумраа хунчир, АУ-ны доктор Ж.Баярмаа Потанины хотир, АУ-ны доктор Г.Энхмаа Могилевийн жамба, дэд проф. Ч.Ерөөлт Сөөгөн боролзгоно, АУ-ны доктор М.Банзаагаяа Нөмрөгт банздоо, АУ-ны доктор Ц.Гүндэгмаа Дэрэвгэр жиргэрүү зэрэг ургамлын фармакологийн судалгаа хийж, АУ-ны болон АШУ-ны докторын зэрэг хамгаалсан байна.

Өнгөрсөн 70 жилийн хугацаанд эм судлалын тэнхимийн багш нар давхардсан тоогоор эрдэм шинжилгээний өгүүлэл 360 гаруй, илтгэлийн хураангуй 370 орчим, халбарчилсан өгүүлэл 150-г нийтлүүлсний гадна технологийн заавар 10, стандарт 27-г боловсруулж, 23 шинэ эмийн бэлдмэл гаргаж 12 патент оновчтой саналын гэрчилгээ авсан байна. Эм судлалын тэнхимийн багш нарын эрдэм судлалын ажлын үр дүнд Панкипсин, Ахилло, Терпенгидрат, Бадглюмицетин, Хоромхон, Эрвалкор, Алт-пант, Гликовит, Сальсомон, Панфеникол зэрэг олон арван эмийн бэлдмэл шинээр гарч эмчилгээний практикт нэвтэрсэн юм. Эм судлалын туршилт шинжилгээний арга зүйг молекул-биологийн түвшинд хүргэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх судалгааны чиглэлээр багш Н.Халиун, Д.Нарантунгалаг, Б.Ариунзаяа нар Япон улсад АУ-ны докторын зэрэг хамгаалсан байна. Одоо тус тэнхимийн эм судлалын лабораторит Монгол улсын эмийн үйлдвэрт үйлдвэрлэсэн зарим эмийн бэлдмэл, ургамал, эрдсийн гаралтай бэлдмэлүүдийн эксперименталь фармакологийн бүхий л туршилт судалгаа хийгдэж байна.

Эм судлалын чиглэлээр нарийвчлан суралцах хүсэлтэй оюутнуудад туршилт судалгааны эм судлалын мэдлэг олгох, орчин үеийн фармакологийн судалгааны арга зүйг эзэмшүүлэх, чадварыг сайжруулах, лабораторийн амьтантай харьцах биоанагаахын ёс зүйн мэдлэг олгох, чөлөөт цагийг зөв боловсон, үр

ашигтайгаар өнгөрүүлэх, судалгааны баг болж ажиллах чадварыг төлөвшүүлэх зорилгоор “Эм судлаач оюутны клуб“-г байгуулан ажиллаж байна.

Эм судлалын тэнхмээс АШУ-ны доктор 2, АУ-ны доктор 21, АУ-ны магистр 27, цолны хувьд профессор 6, дэд профессор 3 төрөн гарчээ.

Эм судлалын тэнхим нь байгуулагдсан цагаасаа Одесса хотын Анагаахын дээд сургууль, И.М Сеченовын нэрэмжит Москва хотын Анагаахын 1-р дээд сургууль, Москва хотын Анагаахын 2-р дээд сургууль, Рязань хотын АУДС, Болгарын София хотын их сургууль зэрэг социалист орнуудтай хамтын ажиллагаатай ажиллаж байв. Цаашид эм судлалын эрдэм шинжилгээний гадаад харилцаа улам өргөжиж ОХУ-ын Эрхүүгийн Анагаахын Их Сургууль, Новосибирскийн Анагаах Ухааны Академи, Япон улсын Токиогийн АУС, Токушимагийн Их сургууль, Шигагийн АШУИС, Тохогийн АУС-ийн эм судлалын тэнхимтэй харилцаа холбоотой ажиллаж байгаа бөгөөд БНСУ-ын Сөүлийн их сургуулийн молекул биологийн тэнхимтэй хамтран “Монголын ховордсон зарим ургамлын геномын судалгаа” сэдвээр төсөлт ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Эм судлалын тэнхим нь сургалтыг онолын ба эмнэл зүйн эм судлалын ухааныг дэлхийн хөгжлийн жишигт нийцүүлэн улам хөгжүүлэх, АШУҮИС-ийн бүрэлдэхүүний сургуулиуд, орон нутгийн коллежийн багшлах боловсон хүчинг чадваржуулан бэлтгэх, сургалтын орчинг бэхжүүлэн хөгжүүлэх, үндэсний хэмжээний эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх үйл ажиллагаанд тэргүүлэх байгууллага болж хөгжих, эм судлалын судалгааны ажлыг олон улсын жишигт нийцсэн туршилт судалгааны лабораторийн орчин, чадварлаг, оюунлаг судлаачдын баг бүрдүүлж эх орны эмийн нөөц, байгалийн баялаг, ном сурвалжид тулгуурлан зах зээлд эрэлттэй шинэ эмийн бэлдмэлийн судалгаа хийж, улмаар эмчилгээний практикт нэвтрүүлэн эдийн засгийн хувьд бие дааж хүчирхэгжих, эмийн зохистой хэрэглээний байдлыг үнэлэх чиг хандлагыг тогтмол судалж, энэ чиглэлээр бодлогын хүрээнд хийх ажлын чиглэлийг боловсруулан гаргадаг байгууллага болох, эмнэл зүйн анагаахын салбарт эм судлаачдын оролцоо, нөлөөг бэхжүүлэхэд чиглэгдэн ажиллаж байна.